



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2024/174/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: С.Баасансүрэн Утас: 7036-2442 Цахим хаяг: Baasansurens@audit.gov.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11-12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12-13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13-14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-16
4. Аудитын тайлан	16-19
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17-18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19-20

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шитгэл
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АРДЫН ДУУ  
БҮЖГИЙН СЭЛЭНГИЙН ДОЛГИО  
ЧУУЛГЫН ДАРГА  
Д.УРАНБИЛЭГ ТАНАА

АодН.Од.ДЗ № ДА-2023/АН/НА-СТА-ТУЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сэлэнгэ аймгийн Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулга нь тайланд онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 27,721.8 мянган төгрөгийн, аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 190,040.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

**Аудитын гол асуудал**

Сэлэнгийн долгио чуулга нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байгаа бөгөөд уг нягтлан бодох бүртгэлийн бодлогын

баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч Соёлын яамны харьяа гүйцэтгэлээр санхүүжиж буй байгууллагын онцлогт тохирохгүй байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Б/39 дүгээр захирамжаар тус чуулгын дарга Д.Уранбилэгийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгож, өндөр насны тэтгэвэрт гаргахаар шийдвэрлэсэн байна.

Дээрх захирамжийн дагуу төрийн албанаас чөлөөлөгдөж, хөдөлмөрийн харилцаа дуусаагүй буюу эрх үүсээгүй байхад өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тусламжид 39,162.7 мянган төгрөгийг олгосон байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус чуулга нь тайлант оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 4 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 96.0 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>303,641,462.54</b>	<b>400,376,758.02</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>54,162,010.54</b>	<b>139,510,200.02</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>54,162,010.54</b>	<b>139,510,200.02</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>54,162,010.54</b>	<b>139,510,200.02</b>
31211	Төрийн сангийн харилцах	54,162,010.54	139,510,200.02
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	<b>12,956.00</b>
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	-	12,956.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>249,479,452.00</b>	<b>260,853,602.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>249,479,452.00</b>	<b>260,853,602.00</b>
35410	Бичиг хэргийн материал	561,400.00	520,900.00
35420	Аж ахуйн материал	4,568,080.00	6,672,080.00
35470	Бусад хангамжийн материал	244,349,972.00	253,660,622.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,121,842,403.39</b>	<b>1,283,638,923.63</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,121,842,403.39</b>	<b>1,283,638,923.63</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,070,202,903.43</b>	<b>1,232,889,423.71</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,055,715,659.47	1,055,715,659.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	(142,491,760.32)	(186,479,912.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	81,840,000.00	81,840,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(81,840,000.00)	(81,840,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	217,779,532.00	457,973,132.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(93,739,776.41)	(122,666,932.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	92,640,521.50	97,871,121.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(65,146,636.19)	(74,662,226.10)
39209	Зам, гүүрийн байгууламж	6,442,401.42	6,442,401.42
39210	Хуримтлагдсан элэгдэл	(997,038.12)	(1,303,819.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,162,723.00	3,162,723.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,162,722.92)	(3,162,723.00)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>51,639,499.96</b>	<b>50,749,499.92</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	52,342,000.00	52,342,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(702,500.04)	(1,592,500.08)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,425,483,865.93</b>	<b>1,684,015,681.65</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,425,483,865.93</b>	<b>1,684,015,681.65</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,425,483,865.93</b>	<b>1,684,015,681.65</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	726,026,057.50	726,026,057.50
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	726,026,057.50	726,026,057.50
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(416,104,867.68)</b>	<b>(157,573,051.96)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,841,849,110.19)	(416,104,867.68)
51220	Тайлант үеийн үр дүн	1,425,744,242.51	258,531,815.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,115,562,676.11	1,115,562,676.11
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,425,483,865.93</b>	<b>1,684,015,681.65</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,518,690,221.15</b>	<b>1,852,912,062.14</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,471,886,703.79</b>	<b>267,383,650.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,471,886,703.79</b>	<b>267,383,650.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>45,011,450.00</b>	<b>43,327,200.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,568,650.00	21,327,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,442,800.00	22,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,183,770,252.79	217,761,800.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	243,105,001.00	6,294,650.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,046,803,517.36</b>	<b>1,585,528,412.14</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>757,381,300.00</b>	<b>1,318,841,613.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	757,381,300.00	1,318,841,613.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>289,422,217.36</b>	<b>266,686,799.14</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	289,422,217.36	266,686,799.14
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,092,945,978.64</b>	<b>1,594,380,246.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,092,945,978.64</b>	<b>1,594,380,246.42</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,044,318,546.64</b>	<b>1,376,649,651.42</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>550,393,125.17</b>	<b>842,611,932.45</b>
210101	Үндсэн цалин	445,453,171.25	550,902,053.17
210102	Нэмэгдэл	80,429,200.92	129,157,215.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	92,320,000.00
210104	Урамшуулал	24,510,753.00	70,232,664.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>69,628,278.68</b>	<b>102,926,785.07</b>
210201	Тэтгэврийн даатгал	48,346,533.01	71,737,230.91
210202	Тэтгэмжийн даатгал	5,690,779.70	8,462,845.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,438,383.66	6,655,876.39
210204	Ажилгүйдлийн даатгал	1,013,871.07	1,462,162.62
210205	Эрүүл мэндийн даатгал	10,138,711.24	14,608,669.63
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>251,773,660.39</b>	<b>256,686,799.14</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,596,917.39	9,230,393.14
210302	Түлш, халаалт	238,950,393.00	238,862,810.00
210303	Цэвэр, бохир ус	6,226,350.00	8,593,596.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,966,499.00</b>	<b>9,978,770.00</b>
210401	Бичиг хэрэг	1,304,900.00	1,657,020.00
210402	Тээвэр, шатахуун	2,395,000.00	700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,481,220.00	2,505,960.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,818,130.00	4,875,790.00
210408	Бараа материал акталсны зардал	10,797,249.00	0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>300,000.00</b>	<b>0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	0

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,293,985.00</b>	<b>21,086,140.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	2,521,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	165,000.00	0
210604	Урсгал засвар	13,128,985.00	18,565,140.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>11,336,200.00</b>	<b>0</b>
210702	Дотоод албан томилолт	11,336,200.00	0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>38,026,035.00</b>	<b>49,281,175.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,026,035.00	49,021,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0	79,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	180,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>90,600,763.40</b>	<b>94,078,049.76</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	10,450,370.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	90,600,763.40	83,627,679.76
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>48,627,432.00</b>	<b>217,730,595.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>48,627,432.00</b>	<b>217,730,595.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,557,432.00	94,939,061.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0	118,341,534.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,070,000.00	4,450,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,425,744,242.51</b>	<b>258,531,815.72</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>1,425,744,242.51</b>	<b>258,531,815.72</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,091,814,967.36</b>	<b>1,628,855,612.14</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>45,011,450.00</b>	<b>43,327,200.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>45,011,450.00</b>	<b>43,327,200.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>45,011,450.00</b>	<b>43,327,200.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,568,650.00	21,327,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,442,800.00	22,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,046,803,517.36</b>	<b>1,585,528,412.14</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>757,381,300.00</b>	<b>1,318,841,613.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	757,381,300.00	1,318,841,613.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>289,422,217.36</b>	<b>266,686,799.14</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	289,422,217.36	266,686,799.14
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,008,979,356.82</b>	<b>1,515,845,022.66</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,008,979,356.82</b>	<b>1,515,845,022.66</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>960,351,924.82</b>	<b>1,298,114,427.66</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>550,652,815.75</b>	<b>842,611,932.45</b>
210101	Үндсэн цалин	445,712,861.83	550,902,053.17

210102	Нэмэгдэл	80,429,200.92	129,157,215.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	92,320,000.00
210104	Урамшуулал	24,510,753.00	70,232,664.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>69,628,278.68</b>	<b>102,939,741.07</b>
210201	Тэтгэврийн даатгал	48,346,533.01	71,737,230.91
210202	Тэтгэмжийн даатгал	5,690,779.70	8,423,237.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,438,383.66	6,695,484.60
210204	Ажилгүйдлийн даатгал	1,013,871.07	1,462,162.62
210205	Эрүүл мэндийн даатгал	10,138,711.24	14,621,625.63
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>251,773,660.39</b>	<b>256,686,799.14</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,596,917.39	9,230,393.14
210302	Түлш, халаалт	238,950,393.00	238,862,810.00
210303	Цэвэр, бохир ус	6,226,350.00	8,593,596.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,493,825.00</b>	<b>10,191,210.00</b>
210401	Бичиг хэрэг	1,443,400.00	2,236,920.00
210402	Тээвэр, шатахуун	2,265,000.00	700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,481,220.00	2,505,960.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,134,205.00	4,508,330.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>4,800,000.00</b>	<b>0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,800,000.00	0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,744,710.00</b>	<b>16,311,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	210,000.00	1,341,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	555,000.00	0
210604	Урсгал засвар	11,979,710.00	14,970,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>11,336,200.00</b>	<b>0</b>
210702	Дотоод албан томилолт	11,336,200.00	0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>49,922,435.00</b>	<b>58,923,275.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,922,435.00	58,663,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0	79,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	180,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>0</b>	<b>10,450,370.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	10,450,370.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>48,627,432.00</b>	<b>217,730,595.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>48,627,432.00</b>	<b>217,730,595.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,557,432.00	94,939,061.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0	118,341,534.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,070,000.00	4,450,000.00
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>82,835,610.54</b>	<b>113,010,589.48</b>
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>28,673,600.00</b>	<b>27,662,400.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>28,673,600.00</b>	<b>27,662,400.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>28,673,600.00</b>	<b>27,662,400.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,673,600.00	27,662,400.00
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(28,673,600.00)</b>	<b>(27,662,400.00)</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>54,162,010.54</b>	<b>85,348,189.48</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	54,162,010.54
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	54,162,010.54	139,510,200.02

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	726,026,057.50	1,115,562,676.11	(1,841,849,110.19)	(260,376.58)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	726,026,057.50	1,115,562,676.11	(1,841,849,110.19)	(260,376.58)
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	<b>Тайлант үеийн үр дүн</b>	-	-	<b>1,425,744,242.51</b>	<b>1,425,744,242.51</b>
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	726,026,057.50	1,115,562,676.11	(416,104,867.68)	1,425,483,865.93
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	726,026,057.50	1,115,562,676.11	(416,104,867.68)	1,425,483,865.93
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	726,026,057.50	1,115,562,676.11	(416,104,867.68)	1,425,483,865.93
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-

16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	258,531,815.72	258,531,815.72
20	<b>2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл</b>	<b>726,026,057.50</b>	<b>1,115,562,676.11</b>	<b>(157,573,051.96)</b>	<b>1,684,015,681.65</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Зөрүү дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,725,392,800.00	1,543,507,422.66	181,885,377.34	89.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,725,392,800.00	1,543,507,422.66	181,885,377.34	89.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,492,911,800.00	1,325,776,827.66	167,134,972.34	88.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	938,551,800.00	842,611,932.45	95,939,867.55	89.78
210101	Үндсэн цалин	546,098,200.00	550,902,053.17	(4,803,853.17)	100.88
210102	Нэмэгдэл	262,130,100.00	129,157,215.28	132,972,884.72	49.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,352,000.00	92,320,000.00	(47,968,000.00)	208.15
210104	Урамшуулал	85,971,500.00	70,232,664.00	15,738,836.00	81.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,358,900.00	102,939,741.07	15,419,158.93	86.97
210201	Тэтгэврийн даатгал	80,816,500.00	71,737,230.91	9,079,269.09	88.77
210202	Тэтгэмжийн даатгал	9,385,700.00	8,423,237.31	962,462.69	89.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,508,400.00	6,695,484.60	812,915.40	89.17
210204	Ажилгүйдлийн даатгал	1,877,300.00	1,462,162.62	415,137.38	77.89
210205	Эрүүл мэндийн даатгал	18,771,000.00	14,621,625.63	4,149,374.37	77.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	315,515,100.00	256,686,799.14	58,828,300.86	81.35
210301	Гэрэл, цахилгаан	69,000,000.00	9,230,393.14	59,769,606.86	13.38
210302	Түлш, халаалт	238,856,000.00	238,862,810.00	(6,810.00)	100.00
210303	Цэвэр, бохир ус	7,659,100.00	8,593,596.00	(934,496.00)	112.2
2104	Хангамж, бараа материалын зардал	7,854,300.00	10,191,210.00	(2,336,910.00)	129.75
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	2,236,920.00	(236,920.00)	111.85
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	700,000.00	(200,000.00)	140.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,615,000.00	2,505,960.00	109,040.00	95.83
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		240,000.00	(240,000.00)	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,739,300.00	4,508,330.00	(1,769,030.00)	164.58
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,312,300.00	42,173,500.00	(1,861,200.00)	104.62
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,312,300.00	27,203,500.00	108,800.00	99.60
210604	Урсгал засвар	13,000,000.00	14,970,000.00	(1,970,000.00)	115.15

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,377,300.00	60,723,275.00	654,025.00	98.93
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,884,200.00	60,463,775.00	420,425.00	99.31
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	79,500.00	500.00	99.38
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	188,100.00		188,100.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	225,000.00	180,000.00	45,000.00	80.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,942,100.00	10,450,370.00	491,730.00	95.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,942,100.00	10,450,370.00	491,730.00	95.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	232,481,000.00	217,730,595.00	14,750,405.00	93.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	232,481,000.00	217,730,595.00	14,750,405.00	93.66
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	109,039,500.00	94,939,061.00	14,100,439.00	87.07
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	118,341,500.00	118,341,534.00	(34.00)	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,100,000.00	4,450,000.00	650,000.00	87.25
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,725,392,800.00	1,674,124,299.14	51,268,500.86	97.02
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,364,110,300.00	1,233,493,400.00	130,616,900.00	90.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,364,110,300.00	1,233,493,400.00	130,616,900.00	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	325,515,100.00	266,686,799.14	58,828,300.86	70.45
132001	Орон нутгийн төсвөөс	325,515,100.00	266,686,799.14	58,828,300.86	81.93
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	35,767,400.00	43,327,200.00	(7,559,800.00)	121.14
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,377,200.00	21,327,200.00	4,050,000.00	84.04
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,390,200.00	22,000,000.00	(11,609,800.00)	211.74
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		54,162,010.54	(54,162,010.54)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		139,510,200.02	(139,510,200.02)	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулга /цаашид Сэлэнгийн долгио чуулга гэх/ нь 2023 онд “Ардын болон язгуур урлагийн мөн чанарыг хадгалан хөгжүүлж, орон нутгийн онцлогт тулгуурлан ардын дуу, бүжгээр урлагийн бүтээл үйлдвэрлэж, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжинэ.” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Сэлэнгийн долгио чуулгын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ардын дуу, бүжиг, хөгжмийн урлагийн өв соёлыг түгээн дэлгэрүүлэх,
- Олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хамтрагч байгууллагуудтай хамтран зохион байгуулах,
- Соёл, урлагаар дамжуулан хүүхэд багачууд, ард иргэдэд бүх нийтийн соёлын боловсрол олгох,
- Соёлын биет бус өв өвлөн тээгч нартай хамтран өв соёлоо сурталчлан таниулж, хамтран ажиллах,
- Уран бүтээлч, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэн мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах,
- Мэргэжлийн байгууллагын орчны болон эрүүл ахуйн стандартыг хэрэгжүүлэх,
- Уран бүтээлийн урын сангийн баяжилтыг шинэ уран бүтээлээр нэмэгдүүлж, чанаржуулах,
- Үзвэр үйлчилгээ, уран бүтээлийн тоглолтоор санхүүгийн нөөцийг бүрдүүлэх.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 185 дугаар тогтоолоор “Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”-ыг баталсан,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- Соёлын сайдын 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/390 дүгээр тушаалаар “Соёлын байгууллагын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал”-ыг шинэчлэн баталсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт, үр нөлөө сул гэж үзлээ.

Сэлэнгийн долгио чуулгын санхүүгийн үйл ажиллагаанд Соёлын яамнаас сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгийн долгио чуулгын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ирсэн байна.

Тус чуулгын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч үр дүнд суурилсан, гүйцэтгэлээр санхүүжиж буй байгууллагын онцлогт тохирохгүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Сэлэнгийн долгио чуулга нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 258,531.8 мянган төгрөгөөр буюу 18.1 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний	Эцсийн	Өөрчлөлт

	үлдэгдэл	үлдэгдэл	
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	54,162.0	139,510.2	85,348.2
Авлага	-	12.9	12.9
Бараа материал	249,479.4	260,853.6	11,374.2
Үндсэн хөрөнгө	1,121,842.4	1,283,638.9	161,796.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,425,483.8</b>	<b>1,684,015.6</b>	<b>258,531.8</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,425,483.8	1,684,015.6	258,531.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,425,483.8</b>	<b>1,684,015.6</b>	<b>258,531.8</b>

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 139,510.2 мянган төгрөг болж 85,348.2 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,283,638.9 мянган төгрөг болж 161,796.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 27,662.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил бэлтгэж, улсын төсвийн болон аймгийн ОНХО, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 217,761.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч, тайлант онд 83,627.7 мянган төгрөгийн элэгдэл нэмж байгуулснаас тус тус шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сэлэнгийн долгио чуулга нь 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,514,336.4 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 20,000.0 мянган төгрөг, нийт зарлагыг 1,534,336.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар бууруулан баталсан байна. Үүнд:

- Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 75,400.7 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 13,000.0 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 35,100.0 мянган төгрөгөөр,
- Томилолт зочны зардлыг 2,200.0 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 19,000.0 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 262,300.0 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 1,000.0 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 72,500.0 мянган төгрөгөөр,

- Урсгал шилжүүлгийн зардлыг 132,360.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж, 921,475.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, барилгын тогтмол зардлын 325,515.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс зэрэг нийт **1,246,990.3** мянган төгрөгийн санхүүжилтийг баталсан байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг 478,402.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож /цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 237,097.8 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 30,677.2 мянган төгрөгөөр, хангамж, эд хогшил, урсгал засварын зардлыг 30,312.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 56,873.7 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 123,441.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн./ нийт **1,725,392.8** мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээр санхүүжүүлэхээр 35,767.4 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 325,515.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,364,110.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 43,327.2 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 266,686.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,233,493.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэн урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,543,507.4 мянган төгрөг буюу 89.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 114,120.7 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлыг 14,750.4 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 58,828.3 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,045,348.6	931,227.9	(114,120.7)	89.1
2	Уран бүтээл хийлгэх	20,000.0	19,828.5	(171.5)	99.1
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж	232,481.0	217,730.6	(14,750.4)	93.6
4	Дээд шатны төсвөөс хуваарилсан	35,767.4	43,327.2	7,559.8	121.1
5	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	325,515.1	266,686.8	(58,828.3)	81.3
6	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	66,280.7	64,706.4	(1,574.3)	97.6
	<b>Нийт дүн</b>	<b>1,725,392.8</b>	<b>1,543,507.4</b>	<b>181,885.4</b>	<b>89.4</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр тус чуулгын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгийн долгио чуулгын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг бэлтгэж байх, үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийг зарцуулах асуудлыг хамт олны хурлаар хэлэлцэн, шийдвэрлэж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгийн долгио чуулгын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,092,945.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,929.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд тус чуулгын батлагдсан төсөвт материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,594,380.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон 15,943.8 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд тус чуулга нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 95,939.8 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 15,419.2 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 58,828.3 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлыг 14,750.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Сэлэнгийн долгио чуулга нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай */бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/* нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал гараагүй болно.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 800.0 мянган төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт, 1,595.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 4,492.5 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгснийг тус тус хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	800.0	1	800.0	100
Албан шаардлага	1	1,595.6	1	1,595.6	100
Зөвлөмж	2	4,492.5	2	4,492.5	100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>6,888.1</b>	<b>4</b>	<b>6,888.1</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Тайлант оны үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг 7,853.7 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг 3,120.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан алдааг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 2,227.8 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>1</sup> илэрснээс 2,227.8 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

#### 5.1 Төлбөрийн акт

1.Тус чуулгын дарга Д.Уранбилэгт өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тусламжийг 37 сараар буюу 1,087.8 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5. дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 2.2 дахь “... Төрийн албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь тухайн албан хаагчийн 36 сарын албан тушаалын үндсэн цалингийн дунджаас ихгүй байна.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэг удаагийн буцалтгүй тусламжийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Албан хаагчдын Улаанбаатар хот, Өмнөговь аймагт томилолтоор ажилласан хугацаанд нийт 1,140.0 мянган төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулан тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5. ... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон унаа, хоолны хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Үр дүнд суурилсан санхүүжилттэй холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт: Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийг зарцуулах асуудлыг хамт олны бус уран сайхны зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн байгаа нь Соёлын сайдын 2023 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн А/390 дугаар тушаалаар баталсан Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлалын 7.2 дахь “**Үр дүнгийн нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг хамт олны хурлын шийдвэр, бусад бичиг баримтыг үндэслэн төсвийн шууд захирагч шийдвэр гаргаж, санхүүжүүлнэ.**” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийг зарцуулах асуудлыг хамт олны хурлаар хэлэлцэн, шийдвэрлэж байх.

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>2</sup>-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### **6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

##### **Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй	1	7,853.7	1	7,853.7			1	7,853.7				

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

хүлээн авсан үндсэн хөрөнгийг дутуу тайлагнасан.												
Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг дутуу тайлагнасан.	1	3,120.0	1	3,120.0				1	3,120.0			
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>10,973.7</b>	<b>1</b>	<b>10,973.7</b>				<b>1</b>	<b>10,973.7</b>			

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал	Тоо	Дүн
Буцалтгүй тусламжийг илүү олгосон.	1	1,087.8	1	1,087.8								
Унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон.	1	1,140.0	1	1,140.0								
Үр дүнд суурилсан санхүүжилтийг уран сайхны зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн.	1						1	-				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>2,227.8</b>	<b>2</b>	<b>2,227.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>